

**ИРГЭД ХАРИЛЦАН ЗОРЧИХ НӨХЦЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ
КИРГИЗ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар /цаашид Хэлэлцэн тохирогч Талууд гэнэ/,

хоёр улсын хоорондох найрсаг харилцааг цаашид хөгжүүлэх эрмэлзлэлийг удирдлага болгон,

эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр иргэдийнхээ харилцан зорчих журмыг боловсронгуй болгох зорилгоор,

дорхи зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

Нэгдүгээр зүйл

Нэг Улсын иргэд энэхүү Хэлэлцээрт заасан хүчин төгөлдөр зорчих бичиг баримтаар нөгөө Улсын нутаг дэвсгэрт, 90 хоног хүртэл хугацаагаар, визгүйгээр орж, гарч, дамжин өнгөрч болно.

Хоёрдугаар зүйл

Нэг Улсын иргэд нөгөө Улсын нутаг дэвсгэрт 90-ээс дээш хоногоор орох, эсхүл 90 хоногийн оршин суух хугацаагаа сунгах хүсэлтэй бол энэхүү Улсын визийг тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын журмын дагуу авах ёстой.

Гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан хүчин төгөлдөр зорчих бичиг баримт гэж дор дурдсаныг хэлнэ:

1. Монгол Улсын иргэдийн хувьд:

- дипломат паспорт
- албан паспорт
- иргэний гадаад паспорт
- хүүхдэд зориулсан хавсралт
- Монгол Улсад буцах үнэмлэх

2. Бүгд Найрамдах Киргиз Улсын иргэдийн хувьд:

- дипломат паспорт
- албан паспорт
- иргэний гадаад паспорт
- Бүгд Найрамдах Киргиз Улсад буцах үнэмлэх

Дөрөвдүгээр зүйл

Дипломат болон консулын байгууллага, түүнчлэн төв байр нь нөгөө Улсын нутаг дэвсгэрт буй олон улсын байгууллагад өөрийн улсаа төлөөлөн ажиллаж буй хүчин төгөлдөр дипломат болон албан паспорттай Хэлэлцэн тохирогч Улсуудын иргэд томилолтынхоо нийт хугацаанд нөгөө Улсын нутаг дэвсгэрт визгүйгээр оршин сууж болно.

Энэхүү зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан хүмүүсийн томилолтын нийт хугацаанд тэдний гэр бүлийн гишүүд, дипломат эсхүл албан паспорттай бол, нөгөө Улсын нутаг дэвсгэрт визгүйгээр оршин сууж болно.

Тавдугаар зүйл

Нэг Улсын дипломат болон консулын байгууллага нь нутаг дэвсгэртээ бүртгэгдэж, байнга томилогдсон нөгөө Улсын худалдаа-эдийн засгийн байгууллагын, түүнчлэн хамтарсан үйлдвэрийн ажилтнуудад Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагаар батламжлагдсан үүсгэн байгуулах тухай баримт бичгийг нь үндэслэн олон удаагийн визийг 2 жил хүртэлх хугацаагаар олгоно.

Зургадугаар зүйл

Улс бүрийн дипломат болон консулын байгууллага нь яам, тусгай газар, эсхүл төрийн бусад байгууллагын албан ёсны захидлыг үндэслэн албаны зорилгоор зорчиж буй эдгээр байгууллагын ажилтнуудад нэг удаад 90-ээс дээшгүй хоногоор оршин суух болон олон удаагийн визийг 1 жил хүртэлх хугацаагаар олгоно.

Долдугаар зүйл

Улс бүрийн дипломат болон консулын байгууллага нь, шаардагдах баримт бичгийг бүрдүүлж ирүүлсэн нөхцөлд, визийг ажлын 5 хоногоос хэтрүүлэхгүй хугацаанд олгоно.

Наймдугаар зүйл

Нэг Улсын иргэд, зорчих зорилгоос үл хамааран нөгөө Улсын нутаг дэвсгэрт олон улсын зорчигч тээврийн, эсхүл Хэлэлцэн тохирогч Талуудын харилцан тохиролцсон шалган нэвтрүүлэх боомтоор орж, гарч, дамжин өнгөрч болно.

Есдүгээр зүйл

Суралцахаар, мөн дадлага хийхээр явж буй оюутан, аспирант, дадлага хийгчдэд олон удаагийн визийг тэдний суралцах болон дадлага хийх нийт хугацаагаар, консулын хураамжгүйгээр олгоно.

Аравдугаар зүйл

Нэг Улсын иргэд нөгөө Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг бол тэд тухайн байнга оршин суугаа Улсын хүчин төгөлдөр хууль дүрмийн дагуу зорчино.

Арваннэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн Улсын иргэдээ нутаг дэвсгэртээ саадгүй хүлээж авах үүрэг хүлээнэ.

Арванхоёрдугаар зүйл

Нэг улсын иргэд нөгөө Улсын нутаг дэвсгэр дээр зорчих бичиг баримтаа үрэгдүүлсэн, эсхүл гэмтээсэн тохиолдолд энэ тухайгаа орон нутгийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх бөгөөд холбогдох Улсынхаа дипломат болон консулын байгууллагаас олгосон хүчин төгөлдөр шинэ бичиг баримтаар оршин суугаа Улсаас гарна.

Арвангуравдугаар зүйл

Нэг Улсын иргэд нөгөө Улсын нутаг дэвсгэрт оршин суух хугацаандаа гадаадын иргэдэд зориулж гаргасан оршин суугаа Улсын хууль, журам, түүний дотор бүртгэгдэх, оршин суух, шилжин суурьших, дамжин өнгөрөх тухай журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Арвандөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талын аль аль нь гадаадын иргэдэд зориулж гаргасан үндэсний хууль тогтоомжийнхоо шаардлагыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдэгдэж байх бөгөөд өөрийн Улсын иргэд дурдсан журмыг нөгөө Улсын нутаг дэвсгэр дээр оршин суух хугацаандаа дагаж мөрдөхөд шаардагдах арга хэмжээг авна.

Арвантавдугаар зүйл

Хүлээн авах боломжгүй гэж үзсэн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын иргэнийг нутаг дэвсгэртээ оруулахаас татгалзах эсхүл оршин суух хугацааг нь зогсоох эрхийг аль ч Улсын хувьд Энэхүү Хэлэлцээрээр хязгаарлахгүй. Энэ тухай шийдвэрээ тайлбарлах албагүй.

Арванзургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд нийгмийн дэг журам, улсын аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг сахин хамгаалах үүднээс энэхүү Хэлэлцээрийн үйлчилгээг бүрэн хэмжээгээр, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоож болно. Гэхдээ тийм арга хэмжээг авахаасаа өмнө Хэлэлцэн тохирогч холбогдох Тал энэ тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дипломат шугамаар аль болох эртнээс, 48 цагаас багагүй хугацаанаас өмнө мэдэгдэх ёстой.

Арвандолдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт харилцан тохиролцсоны дагуу ноот харилцан солилцох замаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Арваннаймдугаар зүйл

Хүчин төгөлдөр үндэсний гадаад паспорт, бусад зорчих бичиг баримтуудыг өөрчлөх эсхүл шинэчлэх тохиолдолд Хэлэлцэн тохирогч холбогдох Тал энэ тухай дипломат шугамаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талд 30-аас доошгүй хоногийн өмнөөс урьдчилан мэдэгдэж, эдгээр бичиг баримтын загварыг хүргүүлнэ.

Арванесдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгохтой холбогдсон дотоодынхоо шаардлагыг биелүүлсэн талаар Хэлэлцэн тохирогч Талууд ноот бичиг солилцсоноос хойш 30 (гуч) хоногийн дараа хүчинтэй болно.

Хорьдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүйгээр байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал түүнийг цуцлах тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтийг бичгээр хүлээж авсан өдрөөс эхлэн 90 (ер) хоног дуустал хүчин төгөлдөр байх болно.

Энэхүү Хэлэлцээрийг Бишкек хотноо 1999 оны 12 дугаар сарын 4-ны өдөр монгол, киргиз, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарах тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд орос хэл дээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг